

## **ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **НЭГ. ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААН:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2019 оны 01 дүгээр сард 2 удаа хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэн батлав.

Төрийн захиргаа болон хил хамгаалах байгууллага, эрүүл мэнд, боловсрол, хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх санаачлага, үр бүтээлтэй ажиллаж хөдөлмөрийн тогтвортой амжилт гарган аймаг орон нутгийн хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулсан дараах хүмүүсийг хамт олон, нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын тодорхойлолтыг тус тус дэмжиж төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх, Сүмийн үйл ажиллагааны зөвшөөрөл сунгах тухай /“Мөнх Амийн Найдвар” Баптист сүм, “Христийн амийн үүд чуулган” протистан сүм/ асуудлыг ИТХ-ын ажилтан Э.Гантулга танилцуулав.

“Мөнх Амийн Найдвар” Баптист сүм, “Христийн амийн үүд чуулган” протистан сүм, Есүс Христийн Хожмын үеийн Гэгээнтнүүдийн Чойбалсан цуглаан сүм, Угтам Тэгчинлэн хийдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тус тус 2 жилийн хугацаатай сунгав.

“Ажлын хэсэг байгуулах тухай” асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Нийгмийн салбарыг хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор батлан гаргасан тогтоол, шийдвэрийн биелэлт, хэрэгжилтэд хяналт тавих зорилго бүхий ажлын хэсгийг байгуулав.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 11 дүгээр хуралдааныг 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 09:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хурлын танхимд хуралдуулахаар тогтов.

Дорнод аймагт хийгдэх хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, түүний гүйцэтгэлийн талаар мэдээлэл сонсов.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” 56 дугаар тогтоолын хэрэгжилтийн тухай мэдээлэл сонсов.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 10 дугаар хуралдааны “Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээний дагуу газрын тос, уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2019 онд Орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх мөнгөн дэмжлэгийн хэмжээг батлах тухай” 04 дүгээр тогтоолын хэрэгжилтийн тухай мэдээлэл сонсох.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 11 дүгээр хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтох тухай.

1. Сүм байгуулах зөвшөөрөл олгох, эсэх тухай. /Алдарт Христийн Дорнод

чуулган/

2. Аймгийн 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай.

3. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2019 онд Дорнод аймагт хийгдэх хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа, түүний гүйцэтгэлийн талаарх мэдээлэл.

4. Ашигт малтмалын газрын тосны газрын 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 1/3729 дугаар албан бичгийг танилцуулж шийдвэрлэх

5. Сургууль цэцэрлэгийн орчны бүс тогтоох тухай

6. “Дорнод аймгийн 9 гайхамшиг”-аар нэрлэгдсэн газруудад авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгөх тухай

7. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

8. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн ээлжит 5 дугаар хуралдааны “Уул овоо, гол мөрнийг аймгийн тахилгатай болгох тухай” 06 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

9. Хэрлэн сумын малчин, мал бүхий иргэдийн санал хүсэлтийн талаарх мэдээлэл.

#### **БУСАД АЖЛЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан “Архигүй Дорнодчуудын Төлөө” хөтөлбөрийг сурталчилах, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, амьдралын хэвшил болгох зорилгоор олон төрлийн нөлөөллийн ажлууд зохион байгуулагдаж бна.

Энэ ажлын хүрээнд АНУ дахь Хавайн улс үндэстний их сургуульд донтолтын зөвлөх багшаар суралцсан, “Хөтөч Гэрэл Сургалт Зөвлөгөө Боловсролын төв” Төрийн бус байгууллагын Тэргүүн, Гэр бүл судлаач, Сэтгэлзүйн магистр, Лектор М.Жаргаланттай хамтран “АРХИГҮЙ АМЬДРАЛ - ГЭР БҮЛИЙН АЗ ЖАРГАЛ” сэдэвт лекц уулзалтыг Төрийн албан хаагчид болон иргэд оюутан сурагчдад зохион байгууллаа.

АЛДАРТ ЭХИЙН 1, 2 дугаар одонгоор шагнагдсан эхчүүдэд хүндэтгэл үзүүлэн, одон гардуулах ёслолын ажиллагаа болж өндөрлөлөө.

Эх үрсийн баярыг угтаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 87 дугаар зарлигаар манай аймгаас “Эхийн алдар-I” одонгоор 26 ээж, “Эхийн алдар-II” одонгоор 291 ээж шагнуулсан.

#### **ХОЁР.ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР**

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар гарган [new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn) сайтад байршуулж 38,75 хувийн биелэлттэй дүгнэгдсэн.

Төрийн байгууллагуудын сайн туршлагыг судлуулах "Харилцан суралцах арга зүй" сэдэвт сургалтыг 2019 оны 05 дугаар сарын 23, 24-ны өдрүүдэд нийт 11 сумын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэргэжилтнүүд болон Халхгол сумын Засаг даргын Тамгын газар, сум дундын эмнэлэг, ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, соёлын төв, ялалт музей, нөмрөгийн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, цагдаагийн тасгийн албан хаагч нарыг оролцуулан удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа.

**ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

**МАЛ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

“Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын эрх зүйн орчныг бүрдүүлэх нь” үндэсний хэлэлцүүлэг төрийн ордонд 2019 оны 5 дугаар сарын 9-ны өдөр зохион байгуулагдаж, аймгаас 14 сумын 27 гаруй малчид, “Эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн зүүн бүсийн сургалт зөвлөгөөн” зохион байгуулагдаж, 30 эрчимсэн аж ахуй эрхлэгчид аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцож салбарын тулгамдсан асуудлаар мэдээлэл авлаа.

**Ботгоны урамшуулал:** “Тэмээ” дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын 2019 оны А/182 дугаар захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор 14 сумын 391 малчны 1186 толгой ботгонд 23,720,000 /Хорин гурван сая, долоон зуун хорин мянга/ төгрөгний урамшууллыг Төрийн банкаар дамжуулан малчдын дансанд байршуулж эхэллээ.

Үржлийн малд үзлэг, ангилалт хийх цөм сүрэг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг Баяндун, Дашбалбар, Халхгол суманд зохион байгуулж эхэллээ.

#### **ГАЗАР ТАРИАЛАН:**

2019 онд 7 сумын нутагт 72,389 га тариалангийн газар эзэмшигч үр тарианы 20 аж ахуй нэгжүүд нийт 40.9 мянган га тариалалт хийх бөгөөд үүнээс 19.6 мянган га-д улаан буудай, 8.2 мянган га-д бусад үр тариа, 700 га-д эмийн ургамал, 4800 га-д тосны ургамал, 7600 га-д малын тэжээлийн ургамал тус тус тариалахаар төлөвлөөд байна.

Дорнод аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийг бүс нутгийн байгаль цаг уурын өөрчлөлт, тухайн жилийн цаг уурын онцлого, аймгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр тасралтгүй хангах хангамжийг бүрдүүлэх, Монгол улсад атар газар эзэмсний 60 жилийн ойн хүрээнд угтаж бүтээлч ажил өрнүүлэх, эдийн засгийн үр ашигтай салбар байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсад Атар газар эзэмсний 60 жилийн ойн нээлт, “Аймгийн тариаланчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, аймгийн Засаг даргын орлогч, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн хөдөө аж ахуй хариуцсан мэргэжилтэн, аймгийн ХХААГ-ын дарга, “Монгол ногоо “ төслийн зохицуулагч Т.Төрмандах, Монгол улсын зөвлөх Агрономич Б. Аюурзана нар оролцлоо. Зөвлөгөөнд аймгийн Засаг даргын дэргэдэх агентлагууд, Сумдын Засаг

дарга нар, ХАА-н тасгийн газар тариалан хариуцсан мэргэжилтнүүд, үр тарианы үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн удирдлагууд, ногоочид, ахмад тариаланчид болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл нийт 142 хүн хамрагдсан.

Монгол ногоо төсөл, МХШТФХолбоо ТББ хамтран “Хүнсний ногоо тариалах агро технологи” сэдэвт сургалт хөтөлбөрийн дагуу явагдаж сургалтыг Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн Хүнсний ногооны секторын Эрдэм шинжилгээний ажилтан Хөдөө аж ахуйн ухааны доктор Ж.Байгалмаа явуулж, 70 гаруй тариаланч ногоочид хамруулсан.

Хүнсний ногоо дэд хөтөлбөрийн хүрээнд Хөлөнбуйр, Булган сумдад Төмс хүнсний ногоо тариалах технологийн сургалтыг зохион байгуулав. Сургалтанд Хөдөө аж ахуйн тасаг, өрхийн тариалан эрхлэгчдэд танхимын болон талбайн сургалтыг хамтатган зохион байгуулсан

Тариалалтын явц 68.7 хувьтэй байгаа бөгөөд 2019 оны 05 сарын 25-ны байдлаар 6 сумын нутагт 12 аж ахуй нэгж 11.4 мянган га-д улаан буудай, 950 га-д тосны ургамал, төмс 53.3 га-д, хүнсний ногоо 8.6 га-д тус тус тариалалт хийгдээд байна.

#### **ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Хүнсний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 болон 16.2 дахь заалтын дагуу **“Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлтийг улсын бүртгэлд бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”-ын төсөлд** Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн дагуу санал авах хэлэлцүүлгийг Хүнс үйлдвэрлэгч 5-н аж ахуйн нэгж /“Дорнод гурил ” ХХК лабораторын эрхлэгч С.Пүрэвсүрэн, “ Бабуб” ХХК захирал П.Алтанцэцэг, “Энхмөнх божу” ХХК М.Цэрэндолгор, “Хөх сүмбэр” ХХК Р.Алтанболор, “Ажиндар” ХХК Д. Уранхайч / оролцож дээр дурьдсан журмын төслийг дэмжлээ. Журамд тусгах нэмэлт санал гараагүй болно.

Орон нутагт “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгж” -ийн нарийн бичгийн дарга Э. Солонготой хамтарч 2019 оны 05 сарын 10-14-ны өдрүүдэд махны үйлдвэрийн газруудаас судалгаа авч суурь судлагаагаа баяжуулж ажилласан.

Монгол Улсад Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих төсөл – “Хувийн хэвшлийн оролцоотойгоор мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн болон хүнсний ногооны үйлдвэрлэлийн нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төсөл”-өөс 2019 оны 05 дугаар сарын 23 -ны өдөр “Хэрлэн фүүдс” ХХК-ний махны үйлдвэрт зохион байгуулагдсан **“Бод, богийн махыг хэрэглээний зориулалтаар шулж ангилах технологи”** сургалтад хамрагдлаа. Сургалтанд махны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 10 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцлоо.

**Тус сургалтанд:**

-Мал төхөөрөх, мах боловсруулах үйлдвэрийн ажиллагсдын эрүүл ахуйн шаардлагууд;

- Ажлын байр, тоног хэрэгслийн цэвэрлэгээ, халдваргүйтгэл;

- Үхрийн махыг шулж ангилах стандарт, хэрэглээний талаарх танилцуулга;

- Хонины махыг шулж ангилах стандарт, хэрэглээний талаарх танилцуулга;

- Мах савлах, шошголох арга;

- Мах ангилснаар гарах эдийн засгийн үр ашиг, жишээ гэсэн аргачлалуудаар сургалт, мэдээлэл хийсэн. Мөн бод, бог малын мах шулж ангилах, махыг савлаж, шошголох үзүүлэх сургалтууд боллоо.

Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дэргэдэх орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн ажлаар Стандарт, хэмжил зүйн хэлтсийн баталгаажуулалтын шинжээч Б. Дүүрэнжаргал, Мал эмнэлгийн газрын улсын ахлах байцаагч Б. Болормаа нарын хамт 2019.05.31 ны өдөр “Талын таван өндөр трейд” ХХК -д тохиролын үнэлгээ хийж ажиллалаа.

**жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр:**

**Сум хөгжүүлэх сангийн үзлэгийг орон нутагт зохион байгууллаа:** Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн сайд, Сангийн сайдын хамтран баталсан удирдамжийн дагуу, аймгийн Засаг даргын А/220 дугаар захирамжаар батлагдсан удирдамжийн хэрэгжилтийг хангах, сум хөгжүүлэх сангийн улсын үзлэгийг орон нутагт зохион байгуулах зорилгоор ажлын хэсэг Халхгол, Матад, Чойбалсан, Гурванзагал, Дашбалбар, Чулуунхороот, Цагаан-овоо, БаянУул, Баяндун, Сэргэлэн, Баянтүмэн, Булган, Хөлөнбуйр, Хэрлэн сумдад ажилласан.

Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд удирдамжид заагдсаны дагуу дараах чиглэлээр үзлэгийн ажлыг зохион байгуулсан.

Аймгийн 14 суманд 3,363,400,000 сая төгрөгийн санхүүжилтийг 1155 иргэн, аж ахуйн нэгжид жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор сум хөгжүүлэх сангийн зээлийг олгосоноос 612 иргэн зээлийн төлөлт дууссан, 246 иргэн, аж ахуйн нэгж нь хэвийн зээлдэгч, 297 иргэн, аж ахуйн нэгж нь байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны А-119 дүгээр тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам” баталсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай хамтран 2019 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Хэнтий аймагт бүсчилсэн сургалт зохион байгуулагдлаа.

Сургалтад 8 хүний бүрэлдэхүүнтэй хамрагдсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, зүүн 5 аймгийн төсөл сонгон шалгаруулах дэд хорооны гишүүд болон аймгийн Засаг даргын тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга болон мэргэжилтэн нийт 50 гаруй албан хаагч оролцлоо.

ЗҮҮН БҮСИЙН “ГОЁЛ- 2019” НААДАМ ШИЛДЭГҮҮДЭЭ ШАЛГАРУУЛЛАА “Зүүн бүсийн гоёл-2019” хувцас загварын наадам өнөөдөр Хөгжимт драмын театр боллоо. Зүүн бүсийн хэмжээнд хувцас үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хүрээнд зохион байгуулдаг уг наадам нь оёдолчид, гуталчдын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага судлах, хүн амын соёл, таашаалд нөлөөлөх зорилготой уг наадам 10 дахь жилдээ зохион байгуулагдаж байна. Энэ жилийн тухайд Зүүн бүсийн гэсэн онцлогтойгоор Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр аймгуудын оёдолчид, загвар зохион бүтээгчид үндэсний, гоёлын, өдөр тутмын хувцас загвар гэсэн төрлүүдээр 300 гаруй бүтээлээр 120 уран бүтээлчид өрсөлдлөө. “Зүүн бүсийн гоёл-2019” Зүүн бүсийн наадмыг аймгийн ЗДТГ, ХХААГ, ХХҮГ, БСУГ, аймгийн Ахуйн үйлчилгээний хоршооллын холбоо зохион хамтран зохион байгуулсан.

**МАЛ ЭМНЭЛГИЙН ТАЛААР:**

Улсын байцаагч тамга түших, мал эмнэлгийн гэрчилгээ олгох заавар, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, архив бичиг хэргийн нууцлалын талаар, цаг үеийн мэдээ, гадаад дотоодод албан томилолтоор явах журам зэрэг мэдээллийн талаар сургалт хийж ажилласан. Байцаагч нарын тамга хэрэглэх журмыг 8 сумын байцаагч нарт танилцуулан гарын үсэг зуруулан ажилласан.

Аймгийн архивын тасагтай хамран Мал эмнэлгийн тасгийн байцаагч нарт улсын байцаагчийн “албан шаардлага”, улсын байцаагчийн “албан дүгнэлт”, Улсын байцаагчийн акт, албан бланк хэвлэн хуваарилж ажилласан.

Мал эмнэлгийн газраас 2019 оны 5 дугаар сарын 15-аас 6 дугаар сарын 15-ныг хүртэлх өдрийг “Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн сарын аян” болгон зарлаж 14 сумын ЗДТГ, МЭТ-тай хамтран ариутгал халдваргүйтгэлийн аяныг эхлүүлээд байна. Аймгийн Засаг даргын 2019 оны А/46 дугаар захирамжаар Баянтүмэн, Матад, Хэрлэн, Чойбалсан сумдын 503,1 мянган толгой бог малыг дархлаажуулалтанд хамруулахаар вакциныг хуваарилан олгож, дархлаажуулалт 45,4 хувьтай үргэлжилж байна.

Матад суманд зохион байгуулагдсан малчдын анхдугаар зөвлөгөөнд Аймгийн ИТХ тэргүүлэгч П.Гэрэлбаатар, ЗДТГ дарга Бат-Өлзий, МЭГ, ХХААГ, НДХ, ХХҮГ, ГБХЗХГ, БОЭТ зэрэг төрийн байгууллагуудтай хамтран оролцож шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, адууны өвчин, эмийн замбараагүй хэрэглээний талаар мэдээлэл хийж, малчдын сонирхсон асуултанд хариулж мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгч ажилласан.

Малчдын анхдугаар зөвлөгөөнд 300 гаруй малчид оролцож, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх гарын авлага, нугалбарыг тараан ажилласан.

Аймгийн Засаг даргын захирамжийн хүрээнд Хан-уулын тахилга-2019, Ирээдүйн түмэн эх-2019 хурдан морьдын уралдааныг аймгийн МСУХ, “Дорнын унага гал” хамтран зохион байгуулж МЭГ-ын эмч, мэргэжилтэн нар уралдааны үеэр мал эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан.

Малын шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн хэмжээнд мал сүргийг угаавар, туулгалт, боловсруулалтад хамруулах, малын хашаа хороо, өтгө бууцыг ариутгах халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулах тухай аймгийн



Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 22-ний А/179 тоот захирамжийг үндэслэн адууны туулгалтын ажлыг 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн зохион байгуулж байна. Тус ажлын хүрээнд аймгийн МСУХ-той хамтарсан төлөвлөгөө боловсруулан ажил эрчимжүүлэх тухай тоотын хамт сумдын МЭТ-т хүргүүлэн, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар 4 сумын 118 өрхийн 8805 толгой адуун сүргийг туулгалтанд хамруулаад байна.

МУЗГ-аас 2019 оныг "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил" болгон зарласантай холбогдуулан хууль тогтоомж төрийн бодлого, шийдвэрийг орон нутагт сурталчилан таниулах, төрийн үйлчилгээний хүртээмж, иргэд олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор 2019 оны 5 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд НДЕГ-ын дэд дарга Г.Сарангаар ахлуулсан ажлын хэсэг аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд Баян-Уул, Баяндун, Цагаан-Овоо гэсэн 3 сумын 320 гаруй иргэдэд Мал эмнэлгийн бодлого чиглэл, мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл өгч ажилласан.

Биокомбинат УҮГ-тай 2019 онд бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хамтран байгуулсантай холбогдуулан орон нутгийн халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх вакциныг татан авч 14 суманд хуваарилан олгож байна. Вакцин нийлүүлэлт 36 хувийн гүйцэтгэлтэй графикт хугацаанаас хоцорч нийлүүлэгдэж байна.

Сумдын Мал эмнэлгийн тасгийн байцаагч нарыг мэргэжил арга зүйгээр хангах, шинээр гарч буй тогтоол, шийдвэр, журмыг хяналтандаа авч мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Мэдээ тайланг цаг хугацаанд нь ирүүлэх тал дээр мэдээний график гаргаж сумдын Мал эмнэлгийн тасгийн байцаагч нарт хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

УМЭАЦТЛ-н захирал, Аймгийн Мал эмнэлгийн газрын даргын баталсан хамтарч ажиллах гэрээ, УМЭАЦТЛ-ын захирлын баталсан удирдамжын дагуу Хөлөнбуйр, Сэргэлэн, Баян-Уул, Баяндун сумдын мэдрэмтгий мал сүрэгт гоц халдварт шүлхий болон бог малын мялзан өвчний байгалын халдвар илрүүлэх ийлдэс судлалын тандалт судалгааг 4 сумын 12 багийн 60 өрхийн 900 толгой мэдрэмтгий малыг хамруулахаар ажиллаж байна.

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

2019 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 40 хоногийн хугацаанд аймгийн төвөөс гарах 5 гол зам дээр ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамтарсан пост гаргаж тээврийн хэрэгслийн яндангийн оч баригч, галын хор, яндан доор хуримтлагдсан өвсийг унагаах сэтгүүр төмөр, ослын гурвалжин, эмийн сан зэргийг шалган бүртгэлийг хангуулан хөдөө орон нутагт зорчуулах ажлыг зохион байгуулсан.

Пост ажиллах хугацаанд 13341 зорчигч, 4461 тээврийн хэрэгсэл бүртгэгдэж яндангийн оч баригч, галын хор, яндан доор хуримтлагдсан өвсийг унагаах сэтгүүр төмөр зэргийг шалган нэвтрүүлсэн.

Монгол улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлиг, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Бүх нийтээр мод сарын ажлыг зохион байгуулах тухай” 2019 оны 04 албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор Дорнод аймгийн Засаг даргын 2016 оны өдрийн А/388 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажлын төлөвлөгөө гаргаж хаврын мод тарих аяныг аймгийн хэмжээнд 2019 оны 04 сарын 25-с 5 сарын 25-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Байгаль орчныг, хамгаалах нөхөн сэргээх зардалд “Аймгийн хэмжээнд 2019 онд хавар, намар мод тарих сарын аяныг зохион байгуулах зардал”-д 10.0 сая төгрөгийг төсөвлөн батлуулж дараах үйл ажиллагаануудыг зохион байгууллаа.

#### ***1. Мод тарих арчлах сургалт***

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 04 албан даалгаврын 3.1/Мод тарих иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг стандартын тарьц, суулгацаар хангах, технологийн зааврын дагуу тарьж ургуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах/-д заалтын хүрээнд Мод тарих арчлах сургалтыг 5 сарын 09-ны өдөр зохион байгууллаа.

Уг сургалтаар гоёлын болон шилмүүст модыг тарьж ургуулах заавар зөвлөмж, Нарс тарих дадлага ажлыг сургуулийн гадна талбайд хийлээ. Сургалтанд 67 байгууллагын 98 албан хаагчид хамрагдлаа. Сургалтын зарыг худалдаа үйлчилгээний Шүр захын үзэл, орон нутгийн телевизүүдээр мэдээллэж ажиллаа.

Сургалтыг Агрономич магистер багш Б.Мөнхцэцэг удирдан явууллаа

*Сургалтын дадлага ажлаар Нарс модны суулгацыг тарьлаа.*

## **2.Тарьц суулгац-2019 үзэсгэлэн худалдаа**

Мод тарих сарын аяныг угтан **Тарьц суулгац-2019** үзэсгэлэн худалдааг 5 дугаар 11-ны өдөр Тусгаар тогтнолын талбайд зохион байгуулсан. Энэхүү үзэсгэлэн худалдаанд Гэрэл сэтгэмж ОНӨҮГазар, БОНХАЖЯамны Ойн мэргэжлийн байгууллагууд болох Нарс мод ХХК, Эрдэс мөнгөн чулуу ХХК, Ойн нөхөрлөлүүдийн төлөөлөл, тарьц суулгац ургуулдаг иргэд өөрсдийн тарьж ургуулсан 16 төрлийн 10 гаруй мянган тарьц, суулгацыг зарж борлуулсан. Мөн мандлын цэцэг, зүлэгний үр, бордоо, багаж хэрэгслийг худалдан борлуулсан.**Тарьц суулгац-2019 үзэсгэлэн худалдаа**

Үзэсгэлэн худалдааны үеэр Ойн инженер Ц.Цэдэндаш Интоор, Мойл, Үхрийн нүд, Тэхийн шээг, Бөөрөлзгөнө, Голт бор, Шар хуайс, Агч нийт 450 ш худалдан борлуулсан. Сэлэнгэ аймгийн иргэн Б.Батхишиг Улиас 800, Хайлаас 1700, Агч 1235, Үхрийн нүд 150, Гүйлс 60, Шар хуайс 690 тус тус борлуулсан. Баян-Уул сумын Ойн нөхөрлөлүүдийн холбоо жимсний мод болон гоёлын модны суулгац, “Эрдэс мөнгөн чулуу” ХХК Үхрийн нүд, Далий ягаан, Нарс, Шинэс, “Нарс мод” ХХК нарсны суулгац тус тус худалдан борлуулсан байна.

## **3.Мод тарих Үндэсний өдрийн нээлтийн арга хэмжээ**

Мод тарих Үндэсний өдрийн нээлтийн үйл ажиллагааг “**Нэг хүүхэд-Нэг мод**” уриалгын хүрээнд 2019 оны 5 сарын 11-ны өдөр Тусгаар тогтнолын талбайд зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагааг Хэрлэн суманд үл ажиллагаа явуулдаг улсын 13, хувийн 3 сургуулийн **Ногоон паспорт** эзэмшигч Эко клубын багш сурагчид бүрэн хамрагдлаа.

**“Ногоон паспорт” эзэмшигч Эко клубын сурагчид**

Дорнод аймагт Мод тарьж ургуулах аяны нээлтийн арга хэмжээг Аймгийн Засаг даргын тамгын газар, Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар, Гэрэл сэтгэмж ОНӨҮГазартай хамтран зохион байгууллаа.

Дорнод аймгийн 2016-2020 хөгжлийн хэтийн зорилтын 24.5 “Ногоон орчинг бүрдүүлэх, мод тарих хөдөлгөөнийг байнгын, өрсөлдөөнт, сайн дурын хэлбэрээр өрнүүлнэ” гэж заасны дагуу гадна орчны ногоон байгууламжаа үлгэр жишээ арчлан ургуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд, өөрийн хашаандаа ногоон орчин бүрдүүлэн хөрш зэргэлдээ айл өрхүүддээ үлгэрлэн ажиллаж буй иргэдийг шагнаж урамшуулдаг уламжлалын дагуу Төрөлх хотынхоо ногоон байгууламжийг нэмэгдүүлэн бүтээлчээр ажиллаж буй Татварын хэлтэсийн хамт олон, Дорнод аймаг дахь Тагнуулын газрын хамт олон, Талын өнгө ХХК хамт олон, Хэрлэн сумын иргэн Н.Магнайбаатар нарт аймгийн Засаг даргын нэрэмжит “Талархал”, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас зохион байгуулсан “Нэг удаагийн Нийлэг хальсан уутнаас татгалзъя” видео бичлэгийн улсын уралдаанд амжилттай оролцож Тэргүүн байранд шалгарсан Дорнод аймгийн 8-р сургуулийн Эко клуб, мөн амжилттай оролцсон ЕБ-ын 1-дүгээр сургуулийн “Ногоон дэлбээ” эко клубт, ЕБ-ын 5 дугаар сургуулийн эко клубт, ЕБ-ын 2 дугаар сургуулийн “Ногоон дэлхий” эко клубт, Баян-Уул сумын “Байгаль ба хүүхэд” экоклубт, Цагаан-овоо сумын “Ногоон ирээдүй” экоклубийн сурагчдад . Байгаль орчин аялал жуулчлалын сайдын Талархалыг гардууллаа.



Нээлтийн үйл ажиллагааны үеэр Нэг удаа хэрэглэгдээд хаягдах “Анонс”-с татгалзах уриалга гарган дэлгэцээр үйл ажиллагааны мэдээллийг гарган бусад төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийг уриаллаа.

Монголын дотоодын аялал жуулчлалын “Улаанбаатар травел экспо-2019” үзэсгэлэн уламжлал ёсоор 2019 оны 05 сарын 24-26-ны өдрүүдэд "Мишээл Экспо" төвд зохион байгуулагдлаа.

Энэхүү арга хэмжээнд түнш аймгаар оролцож Аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Халхгол сумын Ялалт музей, гар урлал, бэлэг дурсгалын үйлдвэрлэл эрхлэгчдийг төлөөлж Цахим хийц, Буйрын толио зэрэг газруудын төлөөллүүд оролцож орон нутаг, өөрсдийн үйл ажиллагаагаа сурталчиллаа.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах олон улсын өдөр жил бүрийн 5 дугаар сарын 22-ны өдөр тохиодог билээ. Тус өдрөөр аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн Дорнод хамгаалалтын захиргаа, Байгаль зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран Найрамдал парк дээр дараах арга хэмжээг зохион байгууллаа.

10.00-11.30 “Шүр зах дээр” байгаль амьтан ургамлын хамгаалах чиглэлээр

нийтэд нөлөөллийн ажил зохион байгуулан 300 орчим иргэн оролцсон .

14.00-21.00 цаг хүртэл “Би байгальд хайртай” хүүхдийн гар зургийн уралдаанд шалгарсан бүтээлээр үзэсгэлэн гаргасан. /Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд/

17.00- 18.30 цаг “Хүүхдийн гар зургийн уралдаан” /Сурагчдад 10-14 настай хүүхдийн дунд /зургийн хэрэгсэлтэй ирэх/ /Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд/

17.00- 18.30 цаг “Нэг уут хог нэг сугалаа” нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулсан. /Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд/

19.00-19.30 иргэд, олон нийтийн дунд байгаль, ан амьтан ургамлыг хамгаалах сэдвээр асуулт хариултын тэмцээн явуулсан. /Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд/

18.00-21.00 Нийт оролцогчид байгаль, ан амьтан ургамлыг хамгаалах уриалгад гарын үсэг зурах үйл ажиллагаа /Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд/

20.00-21.00 Дэлхийн биологийн төрөл зүйлийг хамгаалах өдөрлөгийн хаалтын арга хэмжээ Урлагийн тоглолт, /Жүжигчилсэн үзүүлбэр, Мэргэжлийн дуучдын урлагийн тоглолт, Олон улсын гар зургийн уралдаан, тэмцээний шагнал гардуулах үйл ажиллагаа, /Найрамдал цэцэрлэгт хүрээлэнд/зэрэг арга хэмжээнүүд зохион байгуулан нийт 400 орчим хүүхэд, залуучууд, иргэд олон нийт оролцлоо.

Тус аймгийн Гурванзагал, Чойбалсан сумын нутагт хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд 2019 онд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд зөвлөн туслах, хяналт шалгалтын ажлыг 2019 оны 05 дугаар сарын 13-14 өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

Зураг 1. “Бугант дорф” ХХК. Хайгуулын төлөвлөгөөг зөрчин жонш олборлосон байдал.

**Гурванзагал, Чойбалсан суманд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.**

Гурванзагал сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, Тамгын газрын дарга нарт ажлын хэсгийн удирдамж, бүрэлдэхүүнийг танилцуулан, орон нутгийн саналыг сонссож, зөвлөгөө, зөвлөмжийг өгсөн.

Шийдвэрлэсэн:

1.“Бугант дорф” ХХК хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайдаа 2019 оны хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэмжээг хэтрүүлэн ашигласан болох нь тогтоогдсон.

Хайгуулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан 3 хэсэг газарт 360 м<sup>3</sup> суваг малталт хийхээр төлөвлөсөн ч батлагдсан төлөвлөгөөг зөрчин, 13 метр гүнтэй нүх ухаж, олборлолт явуулсан байна.

Тиймээс тус аж ахуйн нэгжийн хайгуулын үйл ажиллагааг бүрэн зогсоож, нөхөн сэргээлт хийн хүлээлгэн өгөх үүргийг өгсөн.

“Нью нимон майнинг” ХХК хээрийн анги

**ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ АСУУДЛЫН ХҮРЭЭНД:**

Газрын харилцааны ажилтны өдрийг угтан жил бүр уламжлал болон зохиогддог спортын олон төрөлт тэмцээн болон урлагийн анхдугаар их наадам 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан бөгөөд эдгээр арга хэмжээнд тус газраас Газрын удирдлагын хэлтсийн дарга О.Алтантуяа, Архив бичиг хэргийн эрхлэгч С.Оюунбаатар, урлагийн анхдугаар наадамд мэргэжилтэн Н.Адъяа нар оролцсон бол Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас зохион байгуулсан салбар бүрийн сургалтад Газрын дарга Д.Дамдинбазар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд хамрагдлаа.

Гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилж авсан газрын өмчлөх эрхийг гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх хүсэлт ирүүлсэн 40 иргэдийн гэрээ, хэлцлийг хянан үзэж 12 иргэнд газар өмчлөх эрхийг үлдээн 28 иргэнийг хасах тухай захирамжийн төслийг Газрын даргын 2019 оны 143 тоот албан бичгээр аймгийн Засаг даргад хүргүүлэн ажиллсан байна.

Аймгийн Засаг даргын 2019 оны А/175, А/188, А/189 дүгээр захирамжаар 9 дүгээр багийн Баянтүмэн 1 гудамж 102 “а” тоотын 131 м2 газрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар 9 дүгээр багийн Ардчилал 1 гудамж 110 “а” тоотын 90 м2 газрын худалдаа үйлчилгээ, 7 дугаар багийн Үйлчилгээ 1 гудамж 107 тоотын 950 м2 газрыг боловсролын байгууллагын зориулалтаар тус тус эзэмшүүлэх дуудлага худалдааг зарласан. Тус газар нь дээрх захирамжийн дагуу Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2016 оны 10 дугаар тушаалаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу цахим хэлбэрээр 2019 оны 05 дугаар сард зохион байгууллаа..

Газрын төлбөрт 2019 оны 05 дугаар сарын 28-ны байдлаар сард 37.500,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 41.425,3 мянган төгрөг төвлөрүүлж 110,4 хувиар давуулан биелүүлээд байна. Газрын кадастрын мэдээллийн санд 45 иргэн аж ахуй нэгжийн кадастрын зургийг мэдээллийн санд оруулж өөрчлөлт хийсэн.

Дорнод аймагт Газрын шинэтгэлийн үндэсний хорооны ажлын албаны дарга, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Ц.Ганхүүгээр ахлуулсан ажлын хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г аймаг, орон нутгийн удирдлагууд, холбогдох байгууллага, албан хаагчдад танилцуулах, ойлгуулах, хэрэгжүүлэх ажлыг одоогийн мөрдөгдөж буй хууль, тогтоомж, норм, дүрэм, журмын шаардлагад хэрхэн нийцүүлэн чанарын өндөр түвшинд гүйцэтгэх талаар танилцуулгыг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр хийж мэдээлэл өгч ажилласан.

Улсын тусгай хэрэгцээний Тосон хулстайн Байгалийн нөөц газарт хяналт шалгалт хийх аймгийн Засаг даргын 2019 оны А/253 дугаар ажлын хэсэг томилох тухай захирамжийн дагуу 2019 оны 05 дугаар сарын 23-24-ний өдрүүдэд Хөлөнбуйр,



Цагаан-Овоо сумдад газар ашиглалтын хэрэгжилт болон бэлчээрийн талхагдлын талаар газар дээр нь очиж танилцан газрын байршил, худаг, малын тоон судалгааг гаргуулан ажлын хэсэгт танилцуулан цаашид авах арга хэмжээний талаар зөвлөгөө өгч ажиллаа.

Аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 13 дугаар тогтоолоор орон нутгийн хамгаалалтад авсан 49 байршлын 2999840.57 га газрыг Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер-2 програм хангамжид оруулах ажлын хүрээнд “Байгалийн нөөцийн менежмент бүхий хамгаалалттай газар нутгийн сүлжээ МОН/13/303” төслөөс хэрэгжүүлсэн мэдээллийг шинэчлэн ашигт малтмалын газрын кадастрын албаны бүртгэлтэй тулгаж хил заагийн өөрчлөлт болон давхардлыг арилгах саналыг сумдын ИТХ-д уламжлаад байна.

Энэхүү ажилд тус газраас Газрын тухай багц хууль, журам зааврын хэрэгжилт, 2018-2019 онд орон нутагт зохион байгуулагдахаар төлөвлөгдсөн ажлууд, сумын газар эзэмшил, өмчлөлийн байдал, өвөлжөө, хаваржааны газрыг хэрхэн зөв ашиглах тухай, Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний тухай, газрын кадастрын хэмжилт зураглал, гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран өмчилж авсан газраа гэр бүлийн нэг гишүүнд хэрхэн шилжүүлэх зэрэг мэдээллийг өгөхийн зэрэгцээ иргэдийн санал, асуулгын дагуу дэлгэрэнгүй хариулт өгөх, зөвлөгөө өгсөн.

Тус газрын ГУХ-ын дарга О.Алтантуяа, ГУХ-ын мэргэжилтэн Н.Адъяа нар 2019 оны 05 дугаар сард Матад сумын Засаг дарга Э.Төмөрбаатартай биечлэн уулзаж газартай холбоотой ажлуудыг хэрхэн зохион байгуулж хамтарч ажиллах талаар санал солилцлоо. Учир нь тус сумын Газрын даамал Э.Халиунаа жирэмсэн амаржсаны амралттай бөгөөд түүний оронд одоогоор хүн томилогдоогүй байгаа юм. Иймд Матад сумын Засаг даргад ирүүлсэн газартай холбоотой асуудлыг манай байгууллагын холбогдох мэргэжилтэн хянан үзэж сумын Засаг даргад хэрхэн яаж шийдвэрлэх талаар хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахаар болсон.

Суманд ажиллах хугацаанд сумын Засаг даргад ирүүлсэн иргэн хуулийн этгээдийн өргөдөл, албан бичгийг судлан газар эзэмшигч, ашиглагчдын газрын төлбөрийг барагдуулах зар мэдээг мэдээллийн самбарт байршуулан ажилласан. Мөн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 байршилд

дуудлага худалдааны захирамжийн төсөл бэлтгэн сумын Засаг даргад танилцуулж албажуулахад бэлэн болгох зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэлээ.

**Барилга, хот байгуулалтын ажлын чиглэлээр:**

Хэрлэн суманд шинээр баригдаж байгаа болон он дамжин баригдаж байгаа орон сууц, цэцэрлэгийн барилгуудад 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 2019 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн хооронд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн давтан зааварчилгаа өгч, барилгын талбай дээр хэрхэн аюулгүй ажиллах талаар заавар, зөвлөмж өгч ажиллаа.

Барилгын материал, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Р.Оюунжаргал нь 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Стандарт хэмжил зүйн газарт болсон Дорнод аймгийн ГХБХБГ-ын дэргэдэх Барилгын материалын лабораторийн “Итгэмжлэл” олгох хуралд оролцож, илтгэл тавин амжилттай хамгаалсаны үр дүнд Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/120 дугаар тушаал батлагдан “ИТГЭМЖЛЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ” гардан авлаа.

Халхгол суманд “Сум дундын төв” төслийн хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, спорт заал, эмнэлэг, нутгийн удирдлагын ордон, соёлын төвийн барилгын барилга угсралтын ажлыг “Их модун” ХХК гүйцэтгэж байна.

Тус ажилд аймгийн ГХБХБГ-ын даргын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн Халхгол суманд “Сум дундын төсөл”-д захиалагчийн хяналт хийх ажлын удирдамж-ийн дагуу аймгийн ерөнхий архитектор Ц.Цоггэрэлээр ажлын хэсгийг ахлуулж тус газрын Барилгын материал, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн Р.Оюунжаргал, Лабораторийн шинжээч Э.Золбоо, Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Бат-Эрдэнэ нарын хамт хяналтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

“Хүүхдийн гэр бүлийн төлөө” төрийн бус байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу “Anna home” хүүхдийн асрамжийн газар галд өртсөнтэй холбогдуулан шинээр барих барилгын газрын байршлыг аймгийн ерөнхий архитектор газар дээр нь үзэж судлан Хэрлэн сумын 4 дүгээр багийн нутагт олгохоор төлөвлөв.

“Дорнод их сургуулийн спорт заал”-ны барилгын засварын ажлыг “Арвижих цамхаг” ХХК нь Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамтай шууд гэрээ байгуулан ажиллаж дууссаны дагуу Засгийн газрын 317 дугаар тогтоолыг үндэслэн Газрын даргын тушаалаар ашиглалтад оруулах комисс 2019 оны 05 сарын 24-ний өдөр ажиллаж тус засварын ажлыг ашиглалтанд хүлээн авлаа.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудад шалгарсан компаниудтай Орон нутгийн өмчийн газрын зөвлөмж болон гэрээ байгуулах мэдэгдлийг үндэслэн 24 барилгын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна.

Орон нутгийн төсвийн 21 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Цагдаагийн хэсгийн байрны засвар, тохижилт /Хэрлэн сум 2-р баг/”-ын ажилд “Дорнын их өгөөж” ХХК шалгарч шинэ хаалга болон вакум цонх суулгах, гадна талын төмөр сайтинг хийх ажлууд дуусч, дотор заслын ажил болон паркетан шалны ажил хийгдэж байна.

## ТАВ.ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

### ТӨСВИЙН ОРЛОГЫН ТАЛААР:

Орон нутгийн нийт орлого 28341.4 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 27531.1 сая төгрөг, үүнээс татварын орлого 6994.1 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 7467.7 сая төгрөгт хүрч 0.5 сая төгрөгөөр давж, татварын бус орлого 21347.2 сая төгрөг төлөвлөгдсөнөөс гүйцэтгэл нь 20063.4 сая төгрөгт хүрч 1283.8 сая төгрөгөөр тасарч байна.

### Орон нутгийн төсвийн нийт орлого

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөндүнгээр/	Өөрчлөлт	
			Тоо	Хувь
002 ОРОН НУТГИЙН ОРЛОГО	28,341,374,200.00	27,531,137,442.68	(810,236,757.32)	97.14
003 ТАТВАРЫН ОРЛОГО	6,994,121,600.00	7,467,739,014.03	473,617,414.03	106.77
004 Орлогын албан татвар	3,898,872,500.00	4,541,991,708.01	643,119,208.01	116.50
016 Хөрөнгийн албан татвар	528,278,800.00	484,631,317.99	(43,647,482.01)	91.74

021	Бусад татвар, төлбөр, хураамж	2,566,970,300.00	2,441,115,988.03	(125,854,311.97)	95.10
041	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,347,252,600.00	20,063,398,428.65	(1,283,854,171.35)	93.99
042	Нийтлэг татварын бус орлого	817,224,600.00	1,204,085,552.65	386,860,952.65	147.34
049	Хөрөнгийн орлого	-	-	-	#DIV/0!
056	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	16,060,287,200.00	15,922,929,842.00	(137,357,358.00)	99.14
057	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	-	-	-	#DIV/0!
058	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	13,822,205,800.00	13,781,212,500.00	(40,993,300.00)	99.70
059	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	2,238,081,400.00	2,159,257,898.00	(78,823,502.00)	96.48

### ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ТАЛААР:

Аймгийн төсвийн нийт зарлага 29210,7 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 22387,7 сая төгрөгийн гарсан гүйцэтгэлийг бүрэн санхүүжүүлсэн.

Нийт төсвийн зарлагын

- ✓ Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамжинд 56 %
- ✓ Тогтмол зардалд 4.8 %
- ✓ Бараа үйлчилгээний бусад зардалд 35.7 %
- ✓ Хөрөнгийн зардалд 3.5 % байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 2159,2 сая төгрөг, Аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэгт 3021,9 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр 13781,2 сая төгрөгийг батлагдсан хуваарийн дагуу бүрэн санхүүжүүллээ.

### Орон нутгийн төсвийн нийт зарлага

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө /өссөндүнгээр/	Гүйцэтгэл /өссөн дүнгээр/	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,210,709,500.00	22,387,740,147.75	(6,822,969,352.25)	76.6
Цалинхелсболоннэмэгдэлурамшил	12,874,379,100.00	12,331,706,465.90	(542,672,634.10)	95.8
Ажиллолгогчооснийгмийндаатгалдтө лөхшимтгэл	1,609,080,400.00	1,552,572,675.84	(56,507,724.16)	96.5
Бараа үйлчилгээний бусад зардал	2,814,138,100.00	2,090,897,646.00	(723,240,454.00)	74.3

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,249,930,600.00	969,457,140.91	(280,473,459.09)	77.6
<b>Б. ХӨРӨНГИЙНЗАРДАЛ</b>	<b>4,808,553,700.00</b>	<b>1,031,541,480.20</b>	<b>(3,777,012,219.80)</b>	<b>21.5</b>

ЖИЧ: Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн дэлгэрэнгүй мэдээлэлийг Аймгийн ЗДТГ-ын № 15 тоот өрөө, [www.dornod.gov.mn](http://www.dornod.gov.mn) вэб сайт, 70583034, 70582372 дугаарын утсаар авч болно

### **Зургаа. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

***Нэг. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Биеийн тамир, спортын газар:***

#### **Аймгийн хэмжээний уралдаан, тэмцээн:**

Үндэсний сурын аймгийн нээлтийн харваа 2019 оны 5 дугаар сарын 04, 05-ны өдрүүдэд Буриад сурын улсын мэргэн, аймгийн мэргэн, спортын мастер З.Ариунбатын нэрэмжит болон Сэргэлэн суманд зохион байгуулагдаж, 60 харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдлөө.

Аймгийн Засаг даргын 2017 оны А/245 дугаар захирамжийн дагуу “Дорнод марафон 2019” бүх нийтийн гүйлтийг “Эрчимтэй хөдөлгөөн-Эрүүл амьдрал” уриан дор 5 дахь удаагаа зохион байгуулагдлаа. Марафон 5 зай, төрлөөр явагдаж, 1361 тамирчид хамрагдав.

Аймгийн хүүхдийн спортын VI их наадмын хүрээнд сагсан бөмбөг, волейбол, ширээний теннис, бадминтон, бокс зэрэг 10 төрлүүдээр явагдаж, нийт 12..., тамирчид хамрагдав.

Үндэсний сурын баг, цуваа харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2019 оны 5 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд болж, багийн харваанд Дорнод, Сүхбаатар аймгуудын 7 баг харваачид, цуваа харваанд нийт 98 харваачид оролцож, цэц мэргэнээ сорьж, аваргуудаа шалгаруулав.

Сумдын волейболын аварга шалгаруулах тэмцээнд 23 багийн 230 тамирчин оролцов.

### **Сургалт, зөвлөгөөн:**

“Спорт ба хөгжил” зүүн бүсийн сургалтанд Ерөнхий боловсролын сургуулийн Биеийн тамирын багш нар, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын арга зүйч, дасгалжуулагч, нярав бичиг хэрэг зэрэг нийт 10 хүн хамрагдав.

### **Бүс, улсын чанартай уралдаан тэмцээн:**

Бүсийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнд Дорнод аймгийн баг, тамирчид жүдо, бокс, хөлбөмбөг, бадминтон, хөнгөн атлетик зэрэг спортын 5 төрлөөр 180 тамирчин оролцож, алтан медаль 9, мөнгөн медаль 21, хүрэл медаль 24, тусгай байр 2 тус тус хүртсэн байна.

**Хоёр. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Боловсрол, соёл, урлагийн газар:**

**Олимпиад:**

Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойн хүрээнд Дорнод аймгийн Халхгол суманд 5 дугаар сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Түүхийн улсын олимпиад 21 аймаг 9 дүүргийн багш сурагчид оролцов.

**Тайлант өдөрлөг:**

“Эрүүл мэнд, саруул ухаан, өв тэгш хүмүүжлийн төлөө” зорилтот жилийн хүрээнд сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 1 дүгээр бүс болох Хэрлэн сумын 2, 6, 14 дүгээр цэцэрлэгүүд Халхын голын дайны ялалтын 80 жилийн ойг угтан “Хамтдаа хөгжье” уриан дор тайлант өдөрлөгийг зохион байгуулж, зорилтот жилийн хүрээн хийсэн ажлуудаа тайлагнав.

“Эрүүл мэнд, саруул ухаан, өв тэгш хүмүүжлийн төлөө” зорилтот жилийн ажлын хүрээнд 5 дугаар сарын 27-ны өдөр Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 4 дүгээр бүс болох Хэрлэн сумын 7, 9, 12, 16 дугаар цэцэрлэгийн нийт 300 гаруй хүүхэд “Туузтай дасгал”-ыг нэгэн зэрэг хийж, эцэг эх, багш нартаа тайлагнав.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн бяцхан хүүхдүүд, багш нарын хамт 5 дугаар сарын 27-ны өдөр “Содон аялгуу” тайлант өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгт зургаан бүлгийн 150 гаруй хүүхэд хамрагдаж, энэ хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагаагаар сурсан эрдмээ эцэг эхчүүддээ тайлагнав.

Дорнод аймаг, ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаар нутгийн хамтын ажиллагааны хүрээнд “Монгол хэл соёлын жил”-ийн үйл ажиллагааг Чита хотод 05 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулав. Үйл ажиллагааны хүрээнд Дорнод аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн тэргүүтэй төлөөлөгчид Өвөрбайгалийн хязгаарын их сургуультай танилцав. Өдөрлөгийг угтан ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаарын Чита хотын 6-17 насны хүүхдүүдийн дунд “Монгол орон миний нүдээр” гар зураг, бүтээлийн уралдааныг зохион байгуулж, 524 бүтээлээр үзэсгэлэн гаргасан байна.

**Халхын голын дайны ялалтын үнэ цэнэ**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 5 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан “Улаанбаатар трэйвл экспо” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнд Халхгол сумын Ялалт музейн хамт олон Халхын голын дайны түүхт газрууд, байгаль, түүхийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдээ, мэдээлэл танилцуулж, үзэсгэлэнд оролцогчид, сонирхогчдод зориулж, музейн үзмэрүүдээ дэлгэн сонирхуулав.



Халхголын ялалтын 80 жилийн ойг тэмдэглэх аймгийн комиссын Хэвлэл мэдээллийн ажлын хэсэг, “Тэд бидний төлөө, Бид тэдний төлөө” аяны баг Халхын голын дайнд оролцсон ахмад дайчдын төрөл төрөгсөдтэй хийх “Дурсамж” уулзалтыг 5 дугаар сарын 27-ны өдөр Шинжлэх ухааны академийн Түүх, археологийн хүрээлэнгийн хурлын танхимд зохион байгуулав. Уулзалтад ахмад дайчдын ар гэрийнхэн, үр хүүхэд, төрөл төрөгсөд нийт 100 гаруй хүн оролцов.

Халхын голын дайны ялалтын түүхт 80 жилийн ойн хүрээнд хойч үедээ эх оронч үзлийг төлөвшүүлэх, тусгаар тогтнолын үнэ цэнийг түгээн дэлгэрүүлэх, ахмад дайчдын алдар гавъяаг мөнхжүүлэх зорилгоор “Тэд бидний төлөө, Бид тэдний төлөө” аяны баг 5 дугаар сарын 29-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Хилийн 0132 дугаар ангийн ажилтнуудад “Халхын голын зарлаагүй дайн” сэдэвт илтгэл танилцуулан, 35 мм-ийн өргөн дэлгэцийн баримтат кино үзүүлэн, түүхийн эд өлгийн зүйлийн үзэсгэлэнг дэлгэв.

Тус аяны баг өнгөрсөн оны 12 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн нийт 5510 км зам туулан 8500 хүнд мэдээлэл түгээн ажиллав.

### **“Боловсролын экспо 2019” үзэсгэлэн:**

Дорнод аймгийн Ерөнхий боловсролын сургууль төгсөгчдөд мэргэжлийн чиг баримжаа олгох мэдээлэл өгөх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Боловсролын экспо 2019” өдөрлөг 3 дахь жилдээ зохион байгуулагдлаа. Дорнод аймаг сүүлийн 5 жил улсад Элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор тасралтгүй тэргүүлж багш, сурагчийг хөгжүүлж байгаа шинэлэг ажил, сургалтын орчин, боловсролын үйлчилгээний чанар хүртээмжид анхааран ажиллаж байгаа юм.

Өдөрлөгийн нээлтийн үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн, аймгийн Засаг даргын орлогч Ч.Ганбат, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг, хэлтсийн удирдлагууд, урилгаар Оросын Холбооны Улсын Өвөрбайгалийн хязгаарын Олон Улсын хамтын ажиллагаа, гадаад худалдаа, эдийн засгийн сайд А.В.Дроботушенко, Өвөрбайгалийн хязгаарын Улсын их сургуулийн орлогч захирал В.В.Кузнецов, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны харъяа Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын захирал Ж.Болормаа тэргүүтэй Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын зөвлөх багш болон арга зүйч багш нар оролцов.

Арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг хэлтсүүд төгсөгчдөд мэргэжлээ зөв сонгох, гадаадын сургалтын тэтгэлэг болон боловсролын зээлийн сангийн талаар мэдээллийн нэгдсэн үйлчилгээ, багшийн хөгжлийн талаар мэдээ, мэдээлэл, Улсын болон анги дэвших, Элсэлтийн ерөнхий шалгалтын хуваарь, шалгалтад хэрхэн бэлтгэх зөвлөгөө, ирээдүйн идэвхтэй иргэн ба бидэнд хэрэгтэй чадварууд, амжилттай оюутан байх аргуудын талаар ахлах ангийн сурагчдад зориулсан лекц, сургалтууд явагдав. Мөн “Би багш” үндэсний контент уралдааны 1 дүгээр шатанд шалгарсан багш нарт шагнал гардуулав.

Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн төсөл хэрэгжүүлэх сургуулиудад болон “Эрүүл мэнд, саруул ухаан, өв тэгш хүмүүжлийн төлөө” зорилтот жилийн төслийн

уралдаанд шалгарсан сургууль, цэцэрлэгүүдэд батламж гардуулж, 16 нас хүрсэн 22 сурагчдад иргэний үнэмлэх гардуулах ажиллагаа зохион байгуулагдав.

### **Сургалт, зөвлөгөөн:**

Аймгийн Төв номын сангаас 5 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд “Бүтээлч хандлага, шинэлэг санаачлага” сургалтыг зохион байгуулав. Сургалтад сумдын Соёлын төвийн болон Ерөнхий боловсролын сургуулиудын Номын санчид хамрагдаж, “Цахим номын ePub пормат”, “Номын сангийн ББК ангилал, ном ангилах арга зүй”, “Бүтээлч хандлага”, “Нээлттэй номын санч”, “Хандлага ба багийн ажил”, “Соёл урлагийн салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн танилцуулга”, “Байгууллагын соёл, харилцаа”, “Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Хувь хүний хөгжил, хандлага өөрчлөлт” зэрэг агуулга, сэдвээр мэдлэгээ дээшлүүлэв.

Англи хэлний Зүүн бүсийн багш нарын анхдугаар чуулган Дорнод аймгийн Чойбалсан хотноо 5 дугаар сарын 18, 19-ний өдрүүдэд болов. Чуулганд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Дундговь аймаг, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны англи хэлний багш оролцон тэргүүн туршлагаасаа хуваалцаж, мэргэжлийнхээ ур чадварыг нэмэгдүүлэв.

Энэхүү үйл ажиллагааг АНУ-ын Элчин сайдын яам, Монгол Улсын Боловсролын их сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн сургууль, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл, урлагийн газар, Хэрлэн сумын 1 дүгээр сургууль хамтран зохион байгуулав.

Энэ оны 5 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Дорнод аймгийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудын арга зүйч, заах аргын нэгдлийн ахлагч нарт “Аюулгүй амьдрах ухаан” сургалтыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулав.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан уг хөтөлбөрийг танилцуулах, хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх энэхүү сургалтаар “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны аюулгүй байдал”-ыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого үйл ажиллагаа, “Гамшгаас хамгаалах хууль, гамшгаас хамгаалах тухай ойлголт”, “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр болон бусад хөтөлбөрүүдийн уялдаа холбоо зэрэг сэдвээр мэдлэг, мэдээллийг олгов.

### **Тэмдэглэлт үйл явдал:**

Олон Улсын музейн өдрийг “Музей нийгмийн соёлын төв-Уламжлалаа ирээдүйд” сэдвийн хүрээнд аймгийн Музейн хамт олны Хэрлэн сумын 11 багийн ахмадууд болон соёлын байгууллагуудын ажилтнуудын дунд “АХА” тэмцээн, аймгийн 9 гайхамшгийг танилцуулж тэмдэглэв.

**Гурав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар:**

***Хүүхдийн хөгжил, оролцооны чиглэлээр:***

Монголын Хүүхдийн ордноос “Хүүхэд багачуудад Монгол үндэстний урлагийн их өв санг түгээн дэлгэрүүлэх, эзэмшүүлэх, өвлүүлэх, тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, соёлын өвийг өвлүүлж, түүгээр бахархах сэтгэлгээг төлөвшүүлэх” зорилгоор зүүн бүсийн аймгуудын хүүхдүүдийн дунд зохион байгуулсан “Монголын хүүхдүүд” урлагийн их наадмыг хамтран зохион байгуулав. Уг наадамд Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн 182 хүүхэд оролцсон. Наадамд Дорнодын хүүхдүүд амжилттай оролцож, ардын дууны төрөлд Дашбалбар сумын сурагч н.Ариунбат, “Дорнын бүжиг” клубын бүжгийн үзүүлбэр тус тус шалгарч, дараагийн шатанд оролцох эрхээ авсан.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн газар, Боловсрол, соёл урлагийн газар хамтран “Хүүхэд, өсвөр үеийнхнийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, урьдчилан сэргийлэх” зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдын дунд “Өсвөрийн сэргийлэгч 2019” АСК тэмцээнийг зохион байгуулав. Тэмцээнд ерөнхий боловсролын 6 сургуулийн 60 суралцагчид оролцов.

Олон Улсын ихрүүдийн өдрийг угтан “Ижил заяа” сэдэвт өдөрлөгийг 3 дахь жилдээ зохион байгуулав. Уг өдөрлөгийг “Нархан” тоглоомын төвд зохион байгуулж, “Ихэр инээд” гэрэл зургийн үзэсгэлэнд 100 ихрийг хамруулан, хөгжөөнт уралдаан тэмцээнийг зохион байгуулж, гарын бэлэг гардуулав.

***Хүүхдийн хамгааллын чиглэлээр:***

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Улс төрийн тойм” нэвтрүүлэгтэй хамтран эмэгтэйчүүдийн 407 дугаар хорих ангид хийсэн уулзалтаар Хэрлэн сумын 2 дугаар багийн харьяат хүмүүжигч Д.Ган-Эрдэнэ нь ээж болон хүүхдүүдтэйгээ уулзах хүсэлт гаргасны дагуу аймгийн Авто тээврийн төвөөс амьжиргааны түвшин доогуур амьдралтай Д-г 2 хүүгийн хамт 2 талын зардлыг дааж, 5 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд тус хорих ангид “Ээжтэйгээ уулзах сайхан” өдөрлөгт оролцоход дэмжлэг үзүүлж, уулзуулав.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газартай хамтран хүүхдийн “Энх зуслан”-ийн үйл ажиллагаанд MNS 5633:2013 стандарт, “Интернет кафе, цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам” MNS 6430:2014 стандартын хэрэгжилтэд хяналт шалгалтыг удирдамжын дагуу зохион байгуулж нийт 5 үйлчилгээний газарт хянах хуудсаар үнэлгээ хийснээр нийтлэг 4-5 зөрчлийг илрүүлж, хугацаатай албан шаардлага хүргүүлэн, хугацаатай ажлын даалгавар өгсөн.

“Анна хоме асрамж, халамжийн төв”-ийн байр гал түймэрт өртсөнтэй холбогдуулан 22 хүүхдийн эсэн мэнд аюулгүй орчинд амьдрах нөхцлийг дэмжиж Нэг цэгийн үйлчилгээний төвд 26 хоног байршуулж, анхан шатны суурь үйлчилгээ, нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг туслалцааг үзүүлж нийт 13,0 сая төгрөгийн хувцас, эд материалын дэмжлэг үзүүлэв.

Цагдаагийн ерөнхий газар, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран Монгол орон даяар өрнүүлсэн “Зөв тусгал” хөдөлгөөний хүрээнд “Хүүхдэд ээлтэй сэтгүүлч” уулзалтыг зохион байгуулж, уулзалтад орон нутгийн хэвлэл, мэдээллийн сэтгүүлчид, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагуудын хэвлэл мэдээллийн ажилтнууд нийт 20 гаруй хүн оролцов. Мөн Инээмсэглэл дүүрэн хүүхэд “New face-2019” хүүхдийн зөвлөгөөн, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн уулзалт, нээлттэй өдөрлөг үйл ажиллагаагаар нийт 2500 гаруй хүнд “Зөв тусгал” уриалгыг хүргэсэн.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газартай хамтран “Хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх, тэднийг замын хөдөлгөөнд зөв оролцох мэдлэгийг олгох “Тод өнгө Дорнодоос” бодит үзүүлэх сургалтыг зохион байгуулав. Сургалтад Хэрлэн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн сурагчид, цэцэрлэгийн ахлах бүлгийн нийт 600 гаруй хүүхдүүд хамрагдав.

### ***Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:***

“Хүүхдийн эрхийг хамгаалахад бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх” зорилтот жилийн хүрээнд “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэе” аймгийн эцэг эхийн зөвлөгөөнийг Хэрэглээний сэтгэл судлалын үндэсний хүрээлэнтэй хамтран зохион байгуулав. Уг зөвлөгөөнд 13 сумын хамтарсан багийн гишүүд, байгууллагын эцэг эхийн зөвлөл, эцэг эхчүүд нийт 520 хүн, “Гэр бүлийн хөгжил, дэвшил хөтөлбөр”-т хамрагдсан 64 өрхийн 142 эцэг эх тус зөвлөгөөнд хамрагдсан.

Эцэг эхчүүдэд хүмүүжлийн эерэг аргын чиглэлээр илтгэл, мэдээлэл, хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээллийг өгч “Хуримын үйлчилгээ”, “Угийн бичиг хөтлөх арга зүй”-н чиглэлээр танилцуулга, мэдээллийг хүргэсэн. Зөвлөгөөнөөс аж ахуй нэгж, байгууллага, эцэг эхчүүд рүү чиглэсэн уриалгыг гаргаж, иргэд олон нийтэд сурталчилсан. “Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид хамгааллын үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх” ажлыг эрчимжүүлэх зорилгоор 14 сумын 24 хамтарсан баг тус бүрт 500,0 мянган төгрөгийг олгох “Санхүүжүүлэх гэрээ”-г байгуулж, гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр баримталж буй бодлогын баримт бичгийн багцыг гардуулсан.

“Гэр бүлийн хөгжил дэвшил хөтөлбөр”-ийн хүрээнд “Гэр бүлийн боловсрол олгох” модуль 1, 2, 3 сургалтыг зохион байгуулж, “Гэр бүл төлөвлөлт”, “Гэр бүлийн үүрэг хариуцлага”, “Хүүхдийн сэтгэл зүйн онцлог”, “Амжиргааг дэмжих хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх”, “Амьдрах ухааны чадвар олгох нь” зэрэг сэдвээр мэдээлэл өгч, мэдлэг, чадварыг олгосон. Хөтөлбөрт хамрагдсан 72 өрхийн 134 гишүүдийг хамруулан гэр бүлийн боловсрол олгохоос гадна 58 өрх угийн бичигтэй болсон. Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн, Хүүхдийг Ивээх сангийн Дорнод аймаг дахь салбартай хамтран “Хамтарсан багийн чадавхийг

бэхжүүлэх нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 13 сумын 24 хамтарсан багийн 124 гишүүдийг хамруулж, чадавхжуулсан.

“Жайка” Олон Улсын байгууллага болон Хүүхдийг ивээх сан, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хамтран хэрэгжүүлж буй “Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэх нь” төсөлд хамрагдаж буй Баян-Уул, Халхгол, Хэрлэн сумын 1 дүгээр багийн хамтарсан багийн 24 гишүүдэд “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” 8 модуль сургалтыг тогтмол зохион байгуулж, нийт 15 иргэн цуврал сургалтад сайн дураараа хамрагдаж байна.

Засгийн газрын “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”, “Хүүхдийн эрхийг хамгаалахад бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилтот жил”-ийн хүрээнд “Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр орон нутагт хэрэгжиж буй үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, эрх зүйн болон сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ, хүүхдийн эрхийн зөрчил, гэр бүлийн хүчирхийллийн дуудлага мэдээллийг хүлээн авч, урьдчилан сэргийлэх, зорилтот өрх гэр бүл, хүүхдийг илрүүлэх” зорилгоор “Явуулын гэр хүрч очих үйлчилгээ”-г Хэрлэн сумын 7, 9 дүгээр багт хүргэж, нийт 1000 гаруй хүүхэд, 420 гаруй насанд хүрэгчдэд мэдээлэл өгч, зорилтот 7 өрхөд нөхцөл байдлын үнэлгээг хийж, нийгмийн ажлын үйлчилгээг шуурхай хүргэж ажилласан.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн газартай хамтран “Хүчирхийлэл үйлдэгчдийн зан үйлд нөлөөлөх” сайн дурын 3 удаагийн сургалтыг зохион байгуулан 42 иргэнийг хамруулж, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлийн үүрэг хариуцлага зэрэг сэдвээр мэдээлэл хүргэж, ганцаарчилсан зөвлөгөөг өгч, хүчирхийлэл илрүүлэлтийн болон сэтгэл ханамжийн судалгааг авав.

Орон нутгийн “Эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хүрээнд “Байгаль ээж ногоон дэлхий” өдөрлөгийг зохион байгуулж, Хэрлэн сумын 11 багийн 70 гаруй иргэдийг хамруулав.

### ***Залуучуудын хөгжил оролцооны чиглэлээр:***

Аймгийн Засаг даргын дэргэдэх Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Залуучууд хөгжлийн төвөөс “Амьдрах ухааны чадвар” олгох сургалтыг 11 байгууллагын 490 өсвөр үе, залуучууд болон байгууллагын ажилтан, албан хаагч, иргэдэд “Өөртөө итгэх итгэл”, “Харилцаа”, “Бусдыг мэдэрч ойлгох”, “Сэтгэлийн хөдөлгөөнөө хянах”, “Стрессийг зохицуулах нь”, “Нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Бэлгийн амьдрал, “Хорт зуршлаас татгалзах”, “Мэргэжил сонголт бидний ирээдүй” зэрэг сэдвүүдээр зохион байгуулав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Боловсрол, соёл урлагийн газартай хамтран “Өсвөр насны хүүхдүүдэд ирээдүйд эзэмших мэргэжлээ зөв сонгох талаар мэдээлэл, зөвлөгөө өгөх” зорилгоор “Ирээдүйн эзэд мэргэжил сонголтын аян”-ыг өрнүүлэв. “Ажил мэргэжилтэй танилцах аялал”, “Боловсролын экспо өдөрлөг”, “Амьдрах ухааны ур чадвар” олгох 12 модуль сургалт, “Мэргэжлээ хэрхэн сонгох вэ?” лекц, сургалтыг цувралаар зохион байгуулахаас гадна “Мэргэжил сонголтын чиг баримжаа авах сорил”-ыг 150 гаруй сурагчид өгч, нийт 600 гаруй сурагчид, эцэг, эхчүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Залуучуудын хөгжлийн төвийн дэргэдэх дэмжих бүлгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор "Залуу

ээжүүд", "Ажлын амт" дэмжих бүлгийн 7 гишүүдэд хамруулсан "Гар урлал"-ын сургалтыг зохион байгуулж, сургалтаар анхан шатны мэдлэг олгож, шvр, сувдыг ашиглан тvлхvврийн оосор бvтээл урлав.

Аймгийн Төв номын сантай хамтран орон нутгийн залуучуудад оюуны хөрөнгө оруулалт хийх, олон нийтэд ном унших сонирхлыг нэмэгдүүлэх, нөлөөлөх, эртэч зан үйлийг төлөвшүүлэх замаар залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй, зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Номтой өглөө” уулзалтыг хуваарийн дагуу тогтмол зохион байгуулж байна. Энэ удаагийн уулзалтад “Бүсийн оношилгоо эмчилгээний төв”-д зохион байгуулж, “Ногоон нүдэн лам, Жаран цагаан хонь” номыг сонгон хэлэлцэв.

***Дөрөв. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Нийгмийн даатгалын хэлтэс***

**Нийгмийн даатгалын үндсэн үзүүлэлт:**

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөө 2019 оны 5 дугаар сард 2,2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 3,0 тэрбум төгрөг төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөг 136,2 хувиар давуулан биелүүлж ажиллав.

№	Сан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Тэтгэврийн даатгалын сан	1491,2	1900,4	127,4
2	Тэтгэмжийн даатгалын сан	154,4	214,8	139,1
3	Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан	135,3	227,9	168,4
4	Ажилгүйдлийн даатгалын сан	30,1	48,2	160,1
5	Эрүүл мэндийн даатгалын сан	389,4	606,4	155,7
	Нийт	2200,4	2997,7	136,2

**Тэтгэврийн даатгалын сан:**

Тэтгэврийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 127.4 хувиар биелүүлсэн бөгөөд уг сангаас нийт 11892 тэтгэвэр авагчдад 4142.6 сая төгрөгийн тэтгэврийг олгосон.

Тэтгэвэр авагчдыг төрлөөр нь авч үзвэл:

Өндөр насны тэтгэвэр 8134 тэтгэвэр авагчдад 2856,9 сая төгрөг,

Тахир дутуугийн тэтгэвэр 2741 тэтгэвэр авагчид 772,3 сая төгрөг,

Тэжээгч алдсан тэтгэвэр 623 тэтгэвэр авагчид 183,4 сая төгрөг,

Цэргийн тэтгэвэр 562 тэтгэвэр авагчид 330,1 сая төгрөгийг тус тус олгосон.

Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Нийгмийн даатгалын хэлтэс 2019 оны 5 дугаар сарын тэтгэврийг олгохдоо 2672,6 төгрөгийг ажил олгогч даатгуулагчаас нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн орлогоос 1470,0 сая төгрөгийг улсын төсвийн татаасаар бүрдүүлэн олгов

#### **Тэтгэмжийн даатгалын сан:**

Нийгмийн даатгалын даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу хөдөлмөрийн чадвар түр алдсан, Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн болон амаржсны тэтгэмж хүссэн 257 даатгуулагчийн өргөдөл, материалыг хүлээн авч шийдвэрлэв. Үүнд:

Аймгийн хэмжээнд 2019 оны 5 дугаар сард тэтгэмжийн даатгалын сангаас 281 даатгуулагчид 165,6 сая төгрөгийн тэтгэмжийг олгоод байна. Үүнийг ангилан үзвэл:

Хөдөлмөрийн чадвараа түр алдсны тэтгэмж 154 даатгуулагчид 19,3 сая төгрөг,

Жирэмсэн болон амаржсны тэтгэмж 97 даатгуулагчид 116,8 сая төгрөг,

Оршуулгын тэтгэмж 27 даатгуулагчид 27,0 сая төгрөгийн тэтгэмж тус тус олгосон байна.

#### **Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сан:**

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 135,3 төгрөг төвлөрүүлэхээс 227,9 төгрөг төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөг 168,4 хувиар давуулан биелүүлж ажиллаж, уг сангаас:

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас нийт 81 иргэнд 35,3 сая төгрөгийг олгосон байна.

Тахир дутуугийн тэтгэвэр 63 иргэнд 31,1 сая төгрөг,

Тэжээгчээ алдсаны тэтгэвэр 15 иргэнд 1,7 сая төгрөг,

Хөдөлмөрийн чадвар түр алдсан 3 иргэнд 2,5 төгрөгийг тус тус олгосон болно.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний эрсдэл өндөр аж ахуйн нэгжүүд болон жижиг, дунд бизнес эрхлэгч, малчдад зориулан Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулахаар зохих журмын дагуу сонгон шалгаруулалтыг зарлаад байна.

Сонгон шалгаруулатад тэнцсэн сургалтын байгууллагатай хамтран 2019 оны 6 дугаар сард багтаан зохион байгуулахаар ажиллаж байна.

#### **Эрүүл мэндийн даатгалын сан:**

Хэрлэн сумын хэмжээнд эхний 5 сарын байдлаар 389,4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 606,4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, эрүүл мэндийн орлогын төвлөгөөнийн биелэлт 155,7 хувиар биелсэн үзүүлэлттэй байна.

Нэг цонхны үйлчилгээгээр давхардсан тоогоор 5291 иргэдэд үйлчилж, “Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай” хуулийн талаар мэдээлэл зөвлөгөө өгч, 4286 иргэний эрүүл мэндийн даатгалын хураамж төлсөн банкны баримтыг үндэслэн эрүүл мэндийн даатгалын дэвтэрт бичилт хийн мэдээллийн баазад бүрэн шивж оруулсан.

Үүнээс төр шимтгэлийг нь хариуцах 1442 иргэний эрүүл мэндийн даатгалын дэвтэрт хугацааны сунгалтыг даатгуулагч бүрээр цаг тухайд нь хийж, мэдээллийн санд бүртгэсэн.

Шинээр 966 иргэнд эрүүл мэндийн даатгалын гэрчилгээг үнэгүй олгосон ба 4 дүгээр сараас эхлэн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу даатгуулагчийн түр тодорхойлолтыг 180 даатгуулагчдад олгоод байна.

#### **Ажилгүйдлийн даатгалын сан:**

Аймгийн хэмжээнд 2019 оны 5 дугаар сард шинээр 36 даатгуулагч ажлаас чөлөөлөгдсний улмаас ажилгүйдлийн тэтгэмж хүссэн өргөдөл ирүүлсэн бөгөөд тухайн сард нийтдээ 104 даатгуулагчид нийт 40,9 сая төгрөгийн тэтгэмж олгов.

#### **Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан хүлээн авалт, өр авлагын талаар:**

2019 оны 5 дугаар сард 781 ажил олгогч байгууллагад ажиллаж буй 19101 даатгуулагчийн шимтгэлийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлэн түүнийг хуваарилав.

Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 2019 онд тус бүр 8,5 хувь болж өөрчлөгдснөөр сард төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ 74,0 сая төгрөг буюу жилд нийгмийн даатгалын санд 888,0 сая төгрөг нэмэгдэж төвлөрөх төлөвлөгөөтэй байна.

Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 05 дугаар тогтоолоор 2019 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320000 төгрөг байхаар шинэчлэн тогтоосноор нийгмийн даатгалын шимтгэлийн хэмжээ нэг даатгуулагчдад ноогдох шимтгэл 19200-20800 төгрөгөөр нэмэгдэж, нийгмийн даатгалын санд жилд 3377,2 сая төгрөгийн шимтгэлийн орлого нэмэгдэж байна.

2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн өр, авлага нийтдээ 571,4 сая төгрөг байгаагаас төсөвт байгууллага 106,7 сая төгрөг, аж ахуйн нэгж байгууллага 464,6 мян төгрөгийн өр, авлага үүсгэсэн байна.

Үүссэн өр авлага барагдуулахаар дараах ажлуудыг зохион байгууллаа.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилах, хянан шийдвэрлэх журмын 9.2.4-т зааснаар 49 аж ахуйн нэгж байгууллагын 217,2 сая төгрөгийн өр, авлагад арилжааны банкин дахь дансны зарлагын гүйлгээг хааж, 15 аж ахуйн нэгж, байгууллагын 45, 7 сая төгрөгийн өр авлага барагдуулсан.



Уг журмын 9.2.5-д зааснаар дараах байгууллагуудтай хуримтлагдсан шимтгэлийн авлага барагдуулахаар гэрээ байгуулж ажилласан. Үүнд: “Цагаан сор” ХХК 9,019 сая төгрөгийн авлагаас 6,0 сая төгрөгийн авлагыг, Радио, телевизийн сүлжээний газар 10,9 сая төгрөгийн авлагаас 7,6 сая төгрөгийн авлагыг, “ЕЕСС” ХХК 4, 5 сая төгрөгийн авлагаас 4,5 сая төгрөгийг гэрээний дагуу тус тус барагдуулсан байна.

Шимтгэлийн авлага барагдуулаагүй “ТОУУ” ХХК-ийг төлбөл зохих шимтгэл, алдангитай тэнцэх хэмжээний авлагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан.

### ***Тав. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар***

#### ***Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө, мэдээллээр хангах үйлчилгээ:***

Ажил хайгч, ажил олоход хүндрэлтэй иргэн, ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч болон эцэг эхэд нийт 89 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө, 158 иргэнд бүлгийн зөвлөгөө, нийт 295 иргэнд ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс хөдөлмөрт бэлтгэх зөвлөгөөнд 63, хөдөлмөр эрхлэлтийн талаар 67, мэргэжил сонголтын талаар 165 иргэнд зөвлөгөө өгөөд байна. Зөвлөгөө мэдээлэлд хамрагдсан иргэдийг насны ангиллаар авч Үзвэл: 25-34 насны иргэд 38 хувийг эзэлж байгаа бол 15-24 насны 29 хувь, 35-44 насны 19 хувь, 45-54 насны иргэд 9 хувь, 60-аас дээш насны иргэд 5 хувийг тус тус эзэлж байна.

Мөн бүлгийн сургалтад хамрагдсан 30 сурагчийн сонирхсон ажил, мэргэжил, онцлог шинжийг танин мэдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Улаанбаатар Төмөр замын Баянтүмэн тасаг, Хилийн 0132 дугаар ангийн үйл ажиллагаатай танилцуулж мэргэжилтэн, албан хаагчидтай уулзалтыг зохион байгуулж, сонирхсон асуултдаа хариултыг бүрэн авсан.

“Боловсролын экспо 2019” өдөрлөгөөр Мэргэжил сонголтын талаар 146 сурагчдад зөвлөгөө, мэдээлэл өгсөн.

Сурагчдыг сонирхол, ур чадвар, мэргэжлийн хэв шинжийг тодорхойлох сорил, тестээр оношилж, тохирсон мэргэжил болон сургуулиа сонгоход нь зөвлөн тусалж, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдлын талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.

Мөн [www.mergejl.mn](http://www.mergejl.mn) сайт, аппликейшнийг 39 сурагчийн гар утсанд суулгаж, ашиглах арга зүйн талаар зөвлөгөө өгч ажиллав.

#### ***Ажлын байрны захиалга, ажилд зуучлагдсан иргэний мэдээ:***


291 аж ахуй нэгж, байгууллага, иргэнээс 493 сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирүүлснийг бүртгэлтэй ажил хайгч иргэдэд утсаар болон орон нутгийн телевиз, байгууллагын албан ёсны сайт, мөн хэвлэмэл хуудсаар байгууллагын мэдээллийн самбар, сошиал орчинд мэдээлж, 379 иргэнийг ажлын байранд зуучилсан. Үүнээс 311 буюу 82,5 хувь нь байнгын ажилд, 68 иргэн буюу 17,5 хувь нь түр ажлын байранд зуучилсан байна.

Уул уурхайн “Шинь Шинь” ХХК-ийн нээлттэй ажлын байрны ярилцлагад 34 иргэн орж, 9 иргэн ажлын байранд тэнцэж 25 иргэн нөөцөд бүртгэгдсэн.

**Бүртгэлтэй ажил хайгч, ажилгүй иргэний хөдөлгөөний мэдээ:**

Мэдээллийн санд 1421 ажил хайгч иргэн бүртгэлтэй байна. Үүнээс эмэгтэй 598. Ажил хайж буй иргэдийг боловсролын түвшингээр авч үзвэл: 52 хувийг бүрэн дунд боловсролтой иргэд, 26 хувийг тусгай, техникийн боловсролтой иргэд, 6 хувийг суурь боловсролтой иргэд, 18 хувийг дээд боловсролтой иргэд эзэлж байна.

Ажил хайгч иргэдийг насны бүлгээр авч үзвэл:



**Гадаадын хөдөлмөр эрхлэлт:**

“Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн дагуу орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй 6 аж ахуй нэгж, байгууллагаас 264 гадаадын ажиллах хүч, мэргэжилтнийг хөдөлмөр эрхлүүлэх хүсэлт гаргаснаас 234 иргэний хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг дэмжиж, 30 иргэний хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг дэмжээгүй байна. Монгол улсын Засгийн газрын 2019 оны 78, 118 дугаар тогтоолууд гарч 1096 гадаад мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгосон байна.

**Хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрийн хүрээнд:**

Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр тогтоолоор батлагдсан хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулалтын ажил хийгдэж байна. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийг сонгон шалгаруулах ажлын хэсэсг хуралдаж, битүүмжлэн ирүүлсэн 105 төслийн баримт бичгийн бүрдэл болон нөхцөл байдлын үнэлгээ, төслийн шаардлагыг хангасан эсэхэд дүгнэлт өгч ажиллав.

Ахмад мэргэжилтний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт хамрагдах хүсэлтэй 58 төслөөс нийт 11 ахмад мэргэжилтний төслийг сонгон шалгаруулж, 24,0 сая төгрөг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэгт нийт 43 иргэний төслөөс 10 иргэн төслийг сонгон шалгаруулж, 50,0 сая төгрөгийг тус тус олгосон.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:**

**Нийгмийн халамжийн тэтгэвэр:**

- Ахмад настны тэтгэвэрт 87 хүн хамрагдаж, 14,8 сая төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй 1350 иргэнд 222,0 сая төгрөг,
- Одой 6 иргэнд 1,0 сая төгрөг,
- Тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны 421 хүүхдэд 74,2 сая төгрөг нийт 1864 иргэн хамрагдаж, 312,3 сая төгрөг зарцуулсан байна.

**Нийгмийн халамжийн тэтгэмж:**

Асаргааны тэтгэмж:

- Ахмад настныг асарч байгаа 671 иргэнд 46,7 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асарч байгаа 268 иргэнд 19,2 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 411 иргэнд 29,4 сая төгрөг,
- Бүтэн өнчин хүүхдийг үрчилж авсан 3 иргэнд 156 мянган төгрөг,
- Бүтэн өнчин хүүхдийг асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа 85 иргэнд 6,3 сая төгрөг,
- Бүтэн өнчин хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа 13 иргэнд 1,0 сая төгрөг,
- Ганц бие ахмад настныг асрамжилж байгаа 4 иргэнд 304,0 мянган төгрөг нийт 1455 иргэнд 103,2 сая төгрөгийг тус тус олгосон.

**Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих тэтгэмж:**

- Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны 260 хүүхдэд 43,6 сая төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 7 иргэнд 420,0 мянган төгрөг,
- Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан 12 иргэн тэтгэмжид 720,0 мянган төгрөг,
- 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 1 иргэнд 1,2 сая төгрөг,
- Гэр оронгүй болсон 2 өрхөд 2,4 сая төгрөг,
- Хорих ангиас суллагдсан 1 иргэнд 1,2 сая төгрөгийг тус тус зарцуулж, нийт 283 иргэнд 49,5 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Эх олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж:**

- Жирэмсэн эхчүүдийн тэтгэмжид 818 иргэнд 27,3 сая төгрөг,
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 4270 эхэд 208,3 сая төгрөг,
- Ихэр хүүхдийн тэтгэмжид 1 иргэнд 2,0 сая төгрөг,
- 0-18 хүртэлх насны 3 ба түүнээс хүүхэдтэй өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмжийг 2 иргэнд 640,0 мянган төгрөгийг нийтдээ 5091 иргэнд 238,2 сая төгрөгийг зарцуулсан байна.

**Ахмад настанд олгох тусламж, хөнгөлөлт:**

Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуульд зааснаар:

- Ахмад настны протез, ортопедийн хэрэгсэлд 178 ахмад настанд 23,2 сая төгрөг,

- Магадлан итгэмжлэгдсэн рашаан сувилалд 65 иргэнд 8,3 сая төгрөг,
- Ахмадын зориулалттай амралт сувилалд 85 иргэнд 11,8 сая төгрөг,
- Нийгмийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмжийн эрх үүсээгүй 1 иргэнд 1,0 сая төгрөгийг нийт 329 иргэнд 44,3 сая төгрөгийн хөнгөлөлтөд хамруулсан.

***Алдар цолтой ахмад настанд улсын төсвөөс олгож байгаа тусламж, хөнгөлөлт:***

- Улсын ударник, гавьяат, төрийн өндөр албан тушаал хашиж байсан 28 ахмад настанд улсын төсвөөс 4,3 сая төгрөгийн тусламж, хөнгөлөлтөд хамруулсан.

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох тусламж, хөнгөлөлт:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хөнгөлөлт тусламжид:

- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протез, ортепедын хөнгөлөлт 64 иргэний 15,0 сая төгрөг,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд олгох түлээ нүүрсний хөнгөлөлтөд 8 иргэнд 1,1 сая төгрөг,
- Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас хөнгөлөлт авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн дотоодын рашаан сувилалд 2 иргэн сувилуулж 434,0 мянган төгрөг,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэг, сургуулийн унааны хөнгөлөлтөд 9 хүүхдэд 2,6 сая төгрөг,
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний оршуулгын зардлыг 3 иргэнд 3,0 сая төгрөг,
- Насанд хүрсэн бүрэн хараагүй иргэний харилцаа холбооны зардал 226 иргэнд 4,3 сая төгрөг, нийт 312 иргэнд 26,5 сая төгрөгийг зарцуулсан.

***Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ, хүүхдийн мөнгөний талаар:***

Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдах хүсэлтэй 41 иргэний өргөдлийг хүлээн авч програмд бүртгэсэн. Өргөдлийн дагуу 41 өрхийг Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамруулж, мэдээллийн санд мэдээллийг оруулан, давхардал, шивэлтийг алдааг засварласан.

Шинээр төрсөн 167 хүүхдийн мэдээллийг төрсний гэрчилгээ болон сумдаас ирүүлсэн жагсаалтын дагуу хүлээн авч өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэн, хүүхдийн мөнгөний үйлчилгээнд хамруулав.

**Хүнсний тэжээлийн дэмжлэг тусламжаа:**

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 14 сумын 2518 өрхийн 7440 том хүн, 6348 хүүхдэд нийт 13788 хүнд хүргэж, 2019 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн байдлаар 169,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалт, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны А/13 дугаар тушаалаар

батлагдсан “Хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний”-ний журмын дагуу хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авах эрх үүсэн 8 өрхийг шинээр хамруулсан.

“Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний журам”-ын 1 дүгээр бүлгийн 1.2-1.5.5 дахь заалтад дурдсан шаардлагуудыг хангаагүй 170 өрхийг амьжиргаа дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрээр үйлчилгээнээс түдгэлзүүлсэн.

***Зорилтот өрхийн хөгжил хамгааллын чиглэлээр:***

“Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдсан иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд хамруулах замаар, амьжиргааны түвшинг дээшлүүлэх үүднээс бүлгийн ногоо, нийтийг хамарсан ажил, зохион байгуулалттай ажлын байранд хэрхэн, яаж хамрагдах мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад нийт зорилтот бүлгийн ажил идэвхтэй хайж байгаа 200 иргэнийг хамруулах бөгөөд 2019 оны эхний 5 сарын байдлаар 60 гаруй иргэнийг хамруулсан.

Мэргэжлийн сургалтын байгууллагатай хамтран өрх толгойлсон, хөгжлийн бэрхшээлтэй 25-50 насны 20 эмэгтэйчүүдийг чадамжийн гэрчилгээ олгох тогоочийн 21 хоногийн онол, дадлага хосолсон сургалтад хамруулсан.

***Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжил хамгаалал:***

Аймгийн Засаг даргын 2019 оны А/161 дүгээр захирамжийн дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг”-ийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд тэгш хамрагдалтын байдалд хяналт, шинжилгээ-үнэлгээ хийх ажлын хүрээнд ерөнхий боловсролын 2 сургууль, сургуулийн өмнөх боловсрол олгох 2 цэцэрлэгийн үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага, нийгмийн ажилтан, багш нартай уулзаж санал хүсэлтийг сонсож, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 5 дугаар сард 2 удаа хуралдаж, 16 хүүхдийн асуудлыг хэлэлцэн 4 хүүхдийг шинээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоож, 13 хүүхдийг эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн хамгааллын үйлчилгээнд холбон зуучилсан.

“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллын хөтөлбөр”-ийн төлөвлөгөөнд тусгаснаар харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайль үсгийн анхан шатны сургалт болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг, эхийн холбоогоор дамжуулан хүргэж буй хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай 10 хүүхдэд гэрт хүрч очих үйлчилгээнд хяналт тавьж ажиллав.

***Зургаа. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
Эрүүл мэндийн газар:***

**Техник, технологи:**

Дорнод аймгийн иргэдээс ирсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдол, талархал, асуулт бүрийг бүртгэж, нэгдсэн мэдээллийн сан үүсгэх зорилгоор Health InMoment веб програмыг ашиглалтад оруулсан.

Орон нутгийн хөгжлийн сангаас 2019 онд Өсвөр үе залуучуудын /14-17 нас/ эрүүл мэндийг дэмжих төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал 29,9 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгчээр “Сүвэн Уул” ХХК шалгарч 28,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 2019 оны 5 дугаар сард нийлүүлсэн.

Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам”, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 01 дүгээр “Эмнэлгийн тоног төхөөрөмжийн ашиглалт, хэвийн үйл ажиллагааг хангах тухай” албан даалгаврын хэрэгжилтийн хүрээнд улсын төсвийн 9,6 сая төгрөгийн санхүүжилтээр эрүүл мэндийн байгууллагуудад ашиглагдаж байгаа 14 нэр төрлийн 197 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийсэн.

“Сувилагч судлаач 20” эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж, сувилахуйн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн сувилахуй чиглэлээр 19 илтгэл танилцуулагдав. Аймгийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд зориулсан “Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо” нэгдсэн хурлын арга хэмжээг 5 дугаар сарын 07-ны өдөр Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сувилахуйн алба, Ахмад сувилагчдын холбооны Дорнод аймгийн салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулсан.

Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох зорилгоор 2019 оны 5 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан “Боловсролын экспо 2019” өдөрлөгт аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн Сувилахуйн алба, “Ягаан цээнэ” өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран сувилагч мэргэжлийг сурталчлан, сувилахуйн тусламж үйлчилгээг танилцуулах “Сувилагч мэргэжил сайхан” үйл ажиллагааг зохион байгуулав. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн 59 байгууллагад 1051 ажиллах хүчин ажиллаж байгаагийн 277 буюу 26,5 хувийг сувилагч мэргэжилтэн эзэлж байгаа ч эрүүл мэндийн байгууллагуудад сувилагчийн орон тоо дутагдалтай, эмч сувилагчийн харьцаа 1:1,5 байгаа нь цаашид сувилагчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Дээрхи байдлаас үндэслэн Ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийн сурагчдад сувилагч мэргэжлийн үнэ цэнийг сурталчлах яриа таниулга хийж, амилуулах суурь тусламж, тарилгын стандарт, гэрийн сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр биет үзүүлэн дэлгэж танилцуулав.

Мөн энэхүү өдөрлөгийн хүрээнд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл, сургалт, сурталчилгааны материал түгээж, аминдэмжүүлэлт хийсэн.

### **“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөр:**

Монгол Улсын Засгийн газраас баталсан “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” хөтөлбөрийн хүрээнд 2-12 насны 19557 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчлэн эрүүлжүүлэх 7 төрлийн эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлж байна.

Эрүүл мэндийн тусгай зөвшөөрөл бүхий “БЭСУ”, “Гандент”, “Супердент”, “Family smile” хувийн хэвшлийн шүдний эмнэлэгүүд эрүүл мэнд, нийгмийн даатгалтай гэрээ байгуулж, тухайн хүүхдийг эмчлэн эрүүлжүүлэх асуудлыг цогцоор шийдэж байгаа ба эдгээр хувийн хэвшлийн шүдний эмнэлгүүдээр 2019 оны 5 дугаар сарын байдлаар 2-12 насны олгохоор тооцсон 623 хүүхдэд 37,0 сая төгрөгийн санхүүжилт зарцуулагдсан байна.

### **“Вируст гепатитийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чадавх сайжруулах”**

Монгол Улсын Засгийн газрын “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны ТА 9438-MON Техник туслалцааны төслийн хүрээнд вируст гепатитын оношилгоо, илрүүлэг, эмчилгээний чиглэлээр “Вируст гепатитийн урьдчилан сэргийлэлт, илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чадавх сайжруулах” сэдэвт сургалтыг аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын 60 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн хамрагдсан.

### **“Цэргийн албан хаагчийн эрүүл мэнд”**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэний цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд хугацаат цэргийн алба хаах насны 385 залуучуудад амьдралын зөв хэвшил, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замаар дамжих халдварт өвчин, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээгээр сургалт зохион байгуулав.

### **“Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа”**

Аймгийн Засаг даргын 2019 оны А/245 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” 6 сарын аяныг зохион байгуулж байна.

Одоогоор Хэрлэн сумын ерөнхий боловсролын 5 сургууль хамруулж, эдгээр сургуулиудаас хамрагдвал зохих 1325 хүүхдэд байхаас хамрагдсан 1180 хүүхэд буюу 89,0 хувьтай, үүнээс сүрьеэгээр тохиолдол 1 илэрч эмчилгээнд хамрагдав.

### **“Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх”**

Аймгийн Засаг даргын А/238 дугаар захирамж “Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, тархалтыг бууруулах ажлыг эрчимжүүлэх” ажлын хүрээнд Сургуулийн өмнөх боловсролын 23 байгууллагуудад дэмжлэгт хяналт хийж, арга зүйн зөвлөгөө өгч, томуу өвчнөөс урьдчилан сэргийлэх 1 төрлийн 460 ширхэг брошур, 43 ширхэг зурагт хуудсыг түгээсэн.

## Долоо. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн Засаг даргын захирамжийн биелэлтэд тогтмол хяналт тавьж, 2019 онд аймгийн Засаг даргын 265 захирамж, 10 сумын Засаг даргын 603 захирамж, сумын Засаг даргын Тамгын газрын даргын 128 тушаалын эрх зүйн үндэслэлийг хянан гарсан зөрчил, дутагдалд 17 удаагийн зөвлөмж хүргүүлээд байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 37 өргөдөл ирүүлснээс 36 өргөдөл гомдлыг шийдвэрлэн холбогдох хариуг иргэдэд өгч 1 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Аймгийн Засаг даргад хандан мөнгөн тусламж хүсч 23 иргэн өргөдөл ирүүлсэн ба 15 иргэнд 10,800,000 /арван сая найман зуун мянга / төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс олгуулах ажлыг зохион байгуулаад байна.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 104,105,106 дугаар тогтоолоор баталсан хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн хэмжээнд ажиллаж байсан гудамж талбайн 32 ширхэг хяналтын камерыг засварлах, тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тендерт шалгарсан “Цахим хийц” ХХК-тай Тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын гэрээ байгууллаа.

Түүнчлэн дээрх хууль, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан төрийн болон төсөвт байгууллага, томоохон аж ахуйн нэгжүүдийг оролцуулсан “Архигүй амьдралыг бид хүснэ” аск тэмцээний 3 дугаар шатны уралдааныг амжилттай зохион байгуулан дүнг гаргаж сум, багт шилжин аялах “Туг”, дэвтрийг гардууллаа.

Мөн 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах” журмын хэрэгжилтийг ханган Газрын тосны салбарын ажилтны өдрийг угтаж тус салбарт ажиллаж буй 50 гаруй иргэдтэй уулзан тэдний санал хүсэлтийг сонсон ажиллалаа.

Түүнчлэн аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд хяналт хийх удирдамжийн дагуу Хэрлэн сумын ЗДТГ-ын 2011-2018 оны Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд зөвлөн тусалж ажилласан.

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанаас ирсэн зөвлөн туслах багт ажлаа танилцуулан мэдээ, тайлан гаргах болон мэдээллийн аюулгүй байдал сэдэвт сургалтад хамрагдлаа.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Архигүй Дорнодчуудын төлөө” хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган Улсын тэргүүний Хан-Уул цогцолбор сургуулийн бага бүлгийн эцэг, эхчүүдийн



дунд зохион байгуулагдсан “Архигүй амьдрал-Аз жаргалтай” аск тэмцээнд шүүгчдийн бүрэлдэхүүнд ажилласан байна.



- Цахим холболт- 42 хадгаламжийн нэгжийн 4663 хуудас баримт
- Хүний нэр-12889
- Байгууллагын нэр-583
- Газар зүйн нэр-876
- Заалт 3964

2019 оны 4 сарын 25-ны байдлаар Дорнод аймгийн Төрийн архивын 1 хөмрөгийн 1 дансны 6 хадгаламжийн нэгжийн 1211 хуудас баримтыг Скайнердаж, 2 хөмрөгийн 2 дансны 34 хадгаламжийн нэгжийн 4300 хуудас баримтыг фотошоф програмаар сэлбэн засав

#### **5.Бусад:**

Хадгаламжийн сангийн цэвэрлэгээ үйлчилгээг 5 сарын 10, 31-ны өдрүүдэд, чийг дулааны хэмжилтийн бүртгэлийг 5 сарын 20,30 -ны өдрүүдэд хөтөлж ажилласан.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР